



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 171/2

Баян-Өндөр сум

Уулын дугуйн өсвөр үе залуучуудын
улсын аварга шалгаруулах
тэмцээнд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уулын дугуйн өсвөр үе залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар)-д, спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д.Дашбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 975,000 (есөн зуун далан таван мянга) төгрөгийг зохих журмын дагуу өсвөрийн шигшээ багийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн
04/42..... дугаар тушаалын хавсралт

УУЛЫН ДУГУЙН ӨСВӨР ҮЕ ЗАЛУУЧУУДЫН
УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Өдөр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд (төгрөгөөр)
1	Хоолны зардал	2	15	20,000	600,000
2	Байрны зардал	1	15	25,000	375,000
	Төсвийн нийт дүн				975,000

---oOo---